



БАТЛАВ,

ШУТИС-ийн ХШУС-ийн ЗАХИРАЛ

В.ӨЛЗИЙБАЯР

## ШУТИС-ийн ОЮУТНЫ МАТЕМАТИКИЙН XXVII ОЛИМПИАД

### УДИРДАМЖ

#### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

ШУТИС болон инженер технологийн мэргэжилтэн бэлтгэдэг их дээд сургуулиудын оюутнуудын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Оюутны Математикийн XXVII Олимпиадыг Математикийн тэнхимийн ахмад багш, дэд профессор, шатрын спортын мастер Ө.Цэрэнгийн нэрэмжит болгон шатрын тэмцээний хамт зохион байгуулж байна.

**ЗОРИЛГО:** Оюутнуудын математик боловсрол, авьяас чадварыг хөгжүүлэх, математикийн хичээлийн үр өгөөжийг дээшлүүлэхэд оршино. Олимпиадыг математикт суралцагч, шатрын спортыг сонирхогч оюутан залуусын эрдмийн баяр болгож сургуулийн хэмжээнд мөрдөгддөг дүрэм журмын хүрээнд шударга, нээлттэй зохион байгуулна.

#### ХЭЗЭЭ, ХААНА:

Оюутны математикийн олимпиадын I даваа	2024.03.29-ны 16.20 цагт бүрэлдэхүүн сургууль тус бүр дээр
Оюутны математикийн олимпиадын II даваа	2024.04.12-ны 16.20 цагт ХШУС
Шатрын тэмцээн	2024.04.13-ны 10.00 цагт ХШУС
Олимпиадын дүнг гаргаж шагнал гардуулах үйл ажиллагаа	2024.04.13-ны 16.00 цагт ХШУС

#### ШАГНАЛ: Математикийн олимпиад

I байр	Өргөмжлөл, үнэ бүхий зүйл, мөнгөн шагнал (20000төг) /1 оюутан/
II байр	Өргөмжлөл, үнэ бүхий зүйл, мөнгөн шагнал (15000төг) /2 оюутан/
III байр	Өргөмжлөл, үнэ бүхий зүйл, мөнгөн шагнал (10000төг) /3 оюутан/
Шагналт байр	Өргөмжлөл, үнэ бүхий зүйл, мөнгөн шагнал (50000төг) /4 оюутан/
Шатрын тэмцээн	
I байр	Өргөмжлөл, үнэ бүхий зүйл, мөнгөн шагнал (10000төг) /1 оюутан/
II байр	Өргөмжлөл, үнэ бүхий зүйл, мөнгөн шагнал (80000төг) /1 оюутан/
III байр	Өргөмжлөл, үнэ бүхий зүйл, мөнгөн шагнал (50000төг) /1 оюутан/

**ЕРӨНХИЙ ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:** ШУТИС-ийн ХШУС-ийн Математикийн тэнхим  
ШУТИС-ийн Бүрэлдэхүүн сургуулиуд  
ШУТИС-ийн Оюутны холбоо

#### ХОЁР. ШУТИС-ИЙН ОЮУТНЫ МАТЕМАТИКИЙН ОЛИМПИАДЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

- 2.1. ШУТИС-ийн Оюутны Математикийн XXVII Олимпиадыг зохион байгуулах, дүгнэх үйл ажиллагааг албан ёсоор томилогдсон зохион байгуулах комисс эрхлэн явуулна.
- 2.2. ШУТИС-ийн Оюутны Математикийн XXVII Олимпиадыг Бүрэлдэхүүн Сургуулийн ба ШУТИС болон бусад их дээд сургуулийн олимпиад гэсэн хоёр даваатайгаар зохион байгуулна.
- 2.3. Бүрэлдэхүүн сургуулийн олимпиадыг албан ёсоор томилогдсон комиссын гишүүн, математикийн тэнхимийн багш нар хариуцан, тухайн сургуулийн Сургалтын алба болон Оюутны холбоотой хамтран зохион байгуулна.
- 2.4. Бүрэлдэхүүн сургуулийн олимпиадад тухайн сургуулийн бүх оюутнууд оролцох эрхтэй байна.
- 2.5. Бүрэлдэхүүн сургуулийн олимпиадад эхний 10 байр эзэлсэн оюутнуудад уг олимпиадын хоёрлын даваанд оролцох эрх олгоно. ШУТИС-ийн орон нутаг дахь салбар сургуулиуд хариуцсан нэг багш, 5 оюутантай оролцно.

- 2.6. Олимпиадын хоёрын даваанд инженер техник, технологийн мэргэжилтэн бэлтгэдэг их дээд сургуулиуд хариуцсан нэг багш, 5 оюутантай урилгаар оролцно.
- 2.7. Шатрын тэмцээнийг ШУТИС-ийн оюутны холбоотой хамтран зохион байгуулна.
- 2.8. Шатрын тэмцээнд бүрэлдэхүүн сургууль тус бүрээс 1-2 оюутан, ХШУС-ийн багш нар оролцно.
- 2.9. Зарыг олимпиад болох өдрөөс 7-гоос доошгүй өдрийн өмнө гаргаж нийтэд мэдээлнэ.

## ГУРАВ. ОЛИМПИАДЫН СЭДВИЙГ БОЛОВСРУУЛАХ, ДҮГНЭХ

### 3.1. Олимпиадын нэгийн даваа

- Бүрэлдэхүүн сургууль тус бүр дээр нэгэн зэрэг зохион байгуулагдана.
- Олимпиадын сэдвийг зохион байгуулах комисс бэлтгэнэ.
- Олимпиад явагдах хугацаа болон шалгалтын явцын үйл ажиллагааны талаар шалгалтын материал дээр тусгаж өгнө.
- Олимпиадын нэгийн давааны дүн мэдээг шалгалт авсан багш нар хавсралт 1-ийн дагуу excel дээр хийж комисст файлаар болон хэвлэмэл байдлаар хүлээлгэн өгнө.

### 3.2. Олимпиадын хоёрын даваа

- Олимпиадын хоёрын даваа ХШУС дээр зохион байгуулагдана.
- Олимпиадын сэдвийг зохион байгуулах комисс боловсруулан ХШУС-ийн захирлаар батлуулна.
- Олимпиад явагдах хугацаа болон шалгалтын явцын үйл ажиллагааны талаар шалгалтын материал дээр тусгаж өгнө.
- Олимпиадын хоёрын даваанд оролцох багуудын мэдээллийг хариуцсан багш нар хавсралт 2 хүснэгтийн дагуу гаргаж комисст файлаар болон хэвлэмэл байдлаар хүлээлгэн өгнө.

### 3.3. Олимпиадын сэдвийн нууцлалыг зохион байгуулах комисс чанд хадгалах ба элдэв маргаантай асуудлыг бүрэн хариуцаж шийдвэрлэнэ.

### 3.4. Олимпиадын тест ба сэдвийг зохион байгуулах комисс засаж 100 хүртэл оноогоор дүгнэнэ.

### 3.5. Шатрын тэмцээний дунг зохион байгуулах комисс тухайн өдөрт гаргана.

### 3.6. Комисс олимпиад болон шатрын тэмцээний дунг нийтэд мэдээлнэ.

## ДӨРӨВ. ОЛИМПИАДЫН БОЛЗОЛ

- 4.1. Олимпиадын хоёрын даваанд оролцогч нийт оюутнуудад батламж, гарын бэлэг гардуулна.
- 4.2. Олимпиадад амжилттай оролцож байр эзэлсэн оюутнуудад өргөмжлөл, үнэ бүхий зүйл, мөнгөн шагнал олгоно.
- 4.3. Олимпиадад ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулийг төлөөлөн оролцсон оюутнуудаас хамгийн өндөр оноо авсан 5 оюутны дундаж оноогоор багийн дунг гаргаж түрүүлсэн багт тэргүүн байрын өргөмжлөл гардуулна.
- 4.4. Багийн дунгээр хамгийн өндөр оноотой ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуульд ШУТИС-ийн математикийн олимпиадын шилжин явах цомыг гардуулна.
- 4.5. Ахмад багш Θ. Цэрэнгийн нэрэмжит ШУТИС-ийн Оюутны Математикийн XXVII олимпиадын хурээнд зохион байгуулагдах шатрын тэмцээнд эхний турван байрт шалгарсан оюутнуудад өргөмжлөл, үнэ бүхий зүйл, мөнгөн шагнал гардуулна.

ШУТИС-ИЙН ХШУС-ИЙН МАТЕМАТИКИЙН ТЭНХИМ

ОЮУТНЫ МАТЕМАТИКИЙН ОЛИМПИАД ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС